



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮнд Үйлдвэрийн Сайдын тушаал

2018 оны 01 сарын 10 өдөр


Дугаар A/06

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

- “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
- “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Түлшний бодлогын газар /Ч.Чулуунбат/, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т тус тус үүрэг болгосугай.
- “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Түлшний бодлогын газар /Ч.Чулуунбат/-т даалгасугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан Уул уурхайн сайд /хуучнаар/-ын 2015 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 196 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 20/8. оны  
0./ дугаар сарын 10 -ны өдрийн  
A/06 дугаар тушаалын хавсралт

## ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ, ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ТАЛБАЙГ БУЦААН ӨГӨХ, ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

### 1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журам нь Газрын тос, уlamжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын, ашиглалтын талбайг гэрээлэгчээс Монгол Улсын Засгийн газар, түүнийг төлөөлөх эрх бүхий байгууллагад буцаан өгөх, Засгийн газар буюу эрх бүхий байгууллага нь дээр дурдсан талбайг гэрээлэгчээс хүлээн авахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Газрын тос, уlamжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаахад энэхүү журмыг баримтална.

1.3. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь эрлийн болон бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн ажил хийгдээгүй хэсгийг буцаан аваадаа тухайн орон нутгийн байгаль орчны байцаагчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

### 2 дугаар зүйл. Талбайг буцаахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Гэрээлэгч нь газрын тос, уlamжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаахад дараах баримт бичгийг бүрдүүлэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

2.1.1. Албан хүсэлт;

2.1.2. Холбогдох зураг, мэдээлэл;

2.1.3. Буцаах талбайд гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан;

2.1.4. Бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсвэл эрлийн гэрээний хэрэгжилт (оноор);

2.1.5. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан;

2.1.6. Жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх ажлын тайлан;

2.1.7. Жил бүрийн орчны хяналт шинжилгээний ажлын тайлан;

2.1.8. Буцаах талбайд хийгдсэн газрын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлт;

2.1.9. Буцаах талбайд өрөмдсөн цооногийн нөхөн сэргээлт хийсэн талбайгаас авсан хөрсний дээжкинд “Хөрсний чанарын стандарт”-ын дагуу итгэмжлэгдсэн лабораториар хийлгэсэн шинжилгээний тайлан, дүгнэлт;

2.1.10. Нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгсөн акт;

2.1.11. Газрын тосны асуудал эрхэлсэн холбогдох төрийн байгууллагууд, Мэргэжлийн хяналтын болон байгаль орчны асуудал эрхэлсэн төв, орон нутгийн байгууллагуудаас өгсөн үүрэг даалгавар, түүний хэрэгжилт;

## 2.1.12.Бусад материал

### **3 дугаар зүйл. Дүгнэлт гаргах**

3.1. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын ажлын алба, орон нутгийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн “талбай буцаан авахад дүгнэлт гаргах үүрэг бүхий” ажлын хэсгийг байгуулна.

3.2.Ажлын хэсгийн ахлагч нь ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор ажлын төлөвлөгөөг батална.

3.3.Ажлын хэсэг, буцааж буй талбайтай газар дээр нь танилцаж, тухайн талбайд хийгдсэн ажил нь холбогдох хууль, журам, стандартын шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргаж, шаардлагатай тохиолдолд илэрсэн зөрчлийг арилгуулах талаар албан шаардлагыг ажлын 10 хоногт багтаан гэрээлэгчид хүргүүлнэ.

3.4.Гэрээлэгч ажлын хэсгээс хүргүүлсэн шаардлагыг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор биелүүлж, ажлын хэсэгт албан бичгээр биелэлтийг ирүүлнэ.

3.5.Ажлын хэсэг шаардлагын биелэлтийг хүлээн авснаас хойш **20** хоногийн дотор газар дээр нь дахин шалгаж дүгнэлт гаргана.

3.6.Ажлын хэсэг нэгдсэн санал дүгнэлтээ газрын тосны болон Байгаль орчны асуудал эрхэлсэн сайдын зөвлөлд тус тус танилцуулан эцсийн шийдвэр гаргуулна.

3.7 Ажлын хэсгийн дүгнэлт, Газрын тосны болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын шийдвэрүүд ил тод нээлттэй байна.

### **4 дүгээр зүйл. Цооног хүлээлгэн өгөх**

4.1.Цооногийг дараах байдлаар битүүмжилсэн байна.

4.1.1.Цооногийн амсрыг төмөр таглаагаар таглан гагнаж битүүмжлэн, 0.5 метрээс багагүй өндөртэй төмөр самбар дээр эрэл эсвэл хайгуулын талбайн нэр, цооногийн дугаар, цооногийг өрөмдсөн огноог тэмдэглэнэ.

4.1.2.Тосны илрэлтэй цооногуудыг хаахдаа перфораци хийсэн интервалаас дээш 50 метрээс багагүй зузаантай цементээр цутган, цооногийн дотоод тоноглолтыг баримтжуулан хүлээлгэн өгнө.

4.2.Цооног орчмын нөлөөлөлд өртсөн газрын гадаргууд “Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, төхникийн ерөнхий шаардлага” MNS 6200:2010 стандартын дагуу нөхөн сэргээлт хийгдсэн байна.

### **5 дугаар зүйл. Бусад**

5.1.Гэрээлэгч талбай буцаан авах эцсийн шийдвэр гарах хүртэл тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлнө.

5.2. Талбай буцаахтай холбогdon гарах зардлыг гэрээлэгч хариуцна.

5.3. Буцаах талбайн цооногоос бусад барилга байгууламж, бараа материалыг бүрэн чөлөөлсөн байна.

5.4. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д заасны дагуу эскроу дансанд байршуулсан хөрөнгө гэрээлэгчийн байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх баталгаа болно. Нөхөн сэргээлтийг дахин гүйцэтгэхтэй холбогdon гарах зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.

5.5. Гэрээлэгч ашиглалтын талбайг бүхэлд нь буцаан өгөхдөө орд хаах, татан буулгах үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр зохицуулна.

-----oOo-----